



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024-08-08 № 335

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Архангай аймгийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч

650230499

үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (*28* хуудас)-ийг хавсаргав.
Хувийг: “Архангай аймгийн сонгуулийн хороо”-нд

Хавсралт *28* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



T. Baygalmaa Т.БАЙГАЛМАА



МОНГОЛ УЛСЫН ОРОН НУТГИЙН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
АРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН
НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

Цэцэрлэг хот 2024 он



АГУУЛГА

НЭГ. БҮТЭН АРХАНГАЙ.....	2
ХОЁР. БОЛОВСРОЛТОЙ АРХАНГАЙ.....	7
ГУРАВ. ӨМЧТЭЙ АРХАНГАЙ	12
ДӨРӨВ. БҮТЭЭЛЧ АРХАНГАЙ	18
ТАВ. ӨРИЙН ДАРАМТГҮЙ АРХАНГАЙ	23
ЗУРГАА. ТӨРИЙН ДАРАМТГҮЙ АРХАНГАЙ	28
ДОЛОО. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ АРХАНГАЙ.....	29
НАЙМ. ШУДАРГА АРХАНГАЙ.....	30
ЕС. НОГООН АРХАНГАЙ.....	31

МОНГОЛ УЛСЫН ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД АРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Архангай аймгийн ардчилсан намаас “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Архангай аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлүүдэд” нийцүүлэн мөрийн хөтөлбөрөө 9 бүлэг бодлогын хүрээнд тодорхойлон дэвшүүлээ.

Энэхүү хөтөлбөр нь архангай аймгийн эдийн засаг эрчимтэй хөгжсөн, хуулийн засаглал, шударга ёс тогтсон, хүн бүр ажил, хөдөлмөр эрхлэн, орлого нь амьдрал ахуйд хүрэлцсэн, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдарсан хүнлэг ардчилсан нийгмийг цогцлоох эрхэм зорилго болгож,

Сонгуулийн мөрийн хөтөлбөрт “БҮТЭН АРДЧИЛАЛ” аяны хүрээнд аймгийн сум, багийн гишүүд, дэмжигчид, бүх намын хороо, иргэний нийгмийн төлөөлөл мэргэжлийн холбоод төрийн бус байгууллагуудаас авсан саналуудыг үндэслэн,

Архангай ардчилсан нам орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд 9 бүлэг “БҮТЭН АРХАНГАЙ - БҮРЭН АРДЧИЛАЛ” эрчимт хөгжлийн хөтөлбөрийг танилцуулж байна.

НЭГ. БҮТЭН АРХАНГАЙ

Архангай аймагт амьдарч байгаа салбар бүрийн иргэдэд чиглэсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД

- 1.1.1. Баялаг бүтээгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийн бизнесийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.2. “Өрх бүр баялаг бүтээгч” үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.1.3. Иргэдийн хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмж, ур чадварт суурилсан цалин хөлс олгох бодлогыг дэмжиж ажиллана.
- 1.1.4. Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хуультогтоомж, дүрэм, журмыг урт хугацаанд тогтвортой, зарчимтай, ойлгомжтой байх эрх зүйн бодлогыг дэмжинэ.
- 1.1.5. Иргэн, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- 1.1.6. Архангай аймгийн 19 сумын бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.1.7. Ахмад, Залуучууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АЖИЛЛАГСАД: МАЛЧИД, ТАРИАЛАНЧИД БОЛОН БУСАД

- 1.2.1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн 30-аас доошгүй хувийг сэргээнэ.
- 1.2.3. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “малжуулах хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.2.4. Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.5. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр

- хэрэгжүүлнэ.
- 1.2.6. Мал эмнэлгийн байгууллагын санаачилгад үндэслэн “Малын эмчилгээ, сувилгааны төв”-ийг төв, суурин газраас зайтай, бэлчээрийн бүс нутагт малчдад ойрхон байгуулах санаачилгыг дэмжинэ.
 - 1.2.7. Малын эмч нарын ур чадварыг дэмжих замаар нэгж малд ногдох мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна.
 - 1.2.8. Цахим хөдөө аж ахуй арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 1.2.9. Шаардлагатай сум багт худаг, уст цэг шинээр гаргаж хүн малын усан хангамжийг нэмэгдүүлнэ.
 - 1.2.10. Нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг тусгай хэрэгцээний сумын отрын бүс нутгаар тогтоон зохион байгуулалттайгаар ашиглуулах.
 - 1.2.11. Бэлчээрийн хөнөөлт амьтантай байгаль орчинд хөнөөлгүй аргаар тэмцэх ажлыг зохион байгуулах.
 - 1.2.12. Малчдад сургалт мэдээлэл хүргэх, мэдлэг олгох ажлыг малчдын бүлэг, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэн хамтарч ажиллах.
 - 1.2.13. Малчдын анхан шатны болон дундын хоршоо, бүлэг, хэсэг байгуулах санаачилгыг дэмжих.
 - 1.2.14. Нийт сүрэгт цөм сүргийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэх
 - 1.2.15. Өвсний нөөц бүрдүүлэх, зориулалттай техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
 - 1.2.16. Малчдын өвөлжөө, хаваржаанд тэжээлийн ургамал тариалах сургалт зохион байгуулж, аргазүйн зөвлөгөө өгөх
 - 1.2.17. Үржлийн болон цөм сүргийн малыг ялган тэмдэглэн, бүртгэлжүүлж, бүртгэл мэдээллийн санд оруулах
 - 1.2.18. Малын гоц халдварт, халдварт, паразит өвчинтэй тэмцэх ажлыг зохионбайгуулж, мал эмнэлэг лабораторийн оношилгооны чадавхыг сайжруулж, мал эмнэлгийн салбарын ажил үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэн малын өвчлөлийг бууруулна.
 - 1.2.19. Атрын аяныг хэрэгжүүлж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон үр тарианы сортыг нутагшуулж, хөрсний үржил шимийг сайжруулж, нэгжээс авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн, үр үржүүлгийн аж ахуйг байгуулах санаачилгыг дэмжин, үрийн агуулах байгуулна.
 - 1.2.20. Орон нутгийн иргэд хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэгцээгээ өөрөө хангах, зоорь, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, “Өрхийн тариалан” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 1.2.21. Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн шинэ техник технологи нэвтрүүлж, тариалангийн бүс нутагт сэргээгдэх эрчим хүчийг ашигласан, усжуулалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
 - 1.2.22. “Эрүүл хүнс-Малчны хотноос” төслийн хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн бүс нутгийг түшиглэн хөгжүүлнэ.
 - 1.2.23. “Малчин эмэгтэйчүүд ба аюулгүй хүнс” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 1.2.24. Байгалийн дагалдах баялаг, мал аж ахуй, газар тариалан болон гахай, тахиа, зөгий зэрэг аж ахуй суурилсан орон нутгийн онцлогийг шингээсэн, шинэ брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

1.3. БАРИЛГЫН САЛБАРТ

- 1.3.1. Орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсдыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.2. Барилгын салбарт ажиллагсдын эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах бодлогыг дэмжин ажиллана.
- 1.3.3. Газар зохион байгуулалт, барилга, хот төлөвлөлтийн цахим

системийг улсын нэгдсэн системтэй уялдуулан хөгжүүлнэ.

- 1.3.4. Шаардлагатай барилга байгууламж, төсөл арга хэмжээний ТЭЗҮ-г жил бүр үе шаттайгаар боловсруулна.
- 1.3.5. Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцуудын гадна фасад, зам талбайг тохижуулж хотын өнгө үзэмжийг сайжруулна.
- 1.3.6. Цэцэрлэг хотод "Булган хангай", "Шинэ наран" зэрэг дахин төлөвлөлт хийгдсэн 4 байршилд суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.
- 1.3.7. Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.4. УУЛ УУРХАЙ БОЛОН ОЛБОРЛОХ САЛБАРТ

- 1.4.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлж, Орхон багт эвдэрч орхигдсон талбайг нөхөн сэргээх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 1.4.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвхөн судлагдаж, зөвшөөрөгдсөн талбайгаас ашиглуулж, нөхөн сэргээлт хийлгэнэ.
- 1.4.3. Улс, аймаг, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээг нэмэгдүүлж, менежментийг сайжруулна.
- 1.4.4. Цэнхэр сумын Орхон багт ажиллаж байгаа алтны уурхайнуудтай үйл ажиллагааны хаалтын гэрээ хийж лицензтэй талбайн ашиглалтыг дуусгаж, нөхөн сэргээлт хийлгэн орон нутагт хүлээж авах ажлыг зохион байгуулна.

1.5. БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ

- 1.5.1. Зэвсэгт хүчний 342 дугаар ангийн үйл ажиллагааг өргөтгөн ажиллана.
- 1.5.2. Цэргийн насны эрчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчтэй иргэдийг эмчлэх эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна.

1.6. ТӨРИЙН АЛБАНЫ ТАЛААР

- 1.6.1. Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж ажиллана.
- 1.6.2. Төрийн үйлчилгээнд "Цахим шилжилт"-ийг үе шаттай хийж, цахим засаглалд шилжих үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- 1.6.3. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.
- 1.6.4. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт сурталчилгааг тогтмолжуулна.
- 1.6.5. Явуулын нэг цонхны үйлчилгээг өргөжүүлж, хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.
- 1.6.6. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог ханган, төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн идэвхтэй түншлэлийг дэмжинэ.
- 1.6.7. Төрийн албыг цомхон чадварлаг болгох бодлогыг дэмжинэ.
- 1.6.8. Архивын сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, архивын үйлчилгээг цахимд шилжүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 1.6.9. Хууль тогтоомжийг сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль эрх, зүйн мэдээллийг цахим хэлбэрээр шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.
- 1.6.10. Багийн төвүүдийг шинэчлэн сайжруулж, иргэд төрийн үйлчилгээг шуурхай авах орчин, нөхцөл бүрдүүлнэ.
- 1.6.11. Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг ханган, мэдлэг, ур чадвар, ажлын үр дүнд суурилсан мерит тогтолцоог бэхжүүлж, төрийн

албаны хүний нөөцийг чадавхжуулна.

- 1.6.12. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
- 1.6.13. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлнэ.
- 1.6.14. Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлэн, авлигыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.6.15. Төрийн байгууллага, албан тушаалтнаас олгогдох аливаа зөвшөөрлийн журмыг цахимжуулж, бизнест ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 1.6.16. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.
- 1.6.17. Иргэдэд хүний эрх, жендерийн боловсрол олгож, жендерийн тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.7. СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРТ

- 1.7.1. Хүний нөөцийн чадавх сул, үйл ажиллагаа нь зогсонги соёл, урлагийн байгууламжуудыг олон нийтийн болгож, хөгжүүлнэ.
- 1.7.2. Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудад менежментийн шинэчлэл хийж, бие даасан байдлыг сайжруулна.
- 1.7.3. Соёл, урлагийн зах зээлд зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах бодлогыг дэмжин ажиллана.
- 1.7.4. Мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага төгсөгч, дадлагажигчдад эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН

- 1.8.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.
- 1.8.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах, нийгмийн үр дүнтэй оролцоог дэмжих, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 1.8.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 1.8.4. Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээ авч ажиллана.
- 1.8.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвүүдийг орон нутагт байгуулна.
- 1.8.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж ажиллана.
- 1.8.7. Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно.
- 1.8.8. Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.
- 1.8.9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орлогыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.9. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН НАСНЫ ХҮҮХДҮҮД

- 1.9.1. Хүүхэд хөгжлийн чиглэлээр байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулна.
- 1.9.2. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандарт хэрэгжүүлнэ.
- 1.9.3. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.9.4. Хүүхдийн эрхийг хангах хөтөлбөр хэрэгжүүлж, хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулна.
- 1.9.5. Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих “эрүүл, чийрэг хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.10. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧИД

- 1.10.1. Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.
- 1.10.2. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын “цөм” хөтөлбөрийг үргэлжлүүлж, төр, орон нутаг, иргэний нийгмийн байгууллага, гэр бүлийн оролцоог өргөжүүлнэ.
- 1.10.3. Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- 1.10.4. Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хуулийг хэрэгжүүлж мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 1.10.5. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, тэдний санаа бодлыг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тусгах зорилгоор насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжинэ.
- 1.10.6. Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаа, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.

1.11. ОЮУТАН

- 1.11.1. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах оюутны идэвхи, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.11.2. Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх хөтөлбөр хэрэгжүүлж, 7 хоногийн цалингийн системийн зарчмаар төгсөгчдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.11.3. Дэлхийн томоохон их сургуулийн хөтөлбөрөөр академик англи хэлийг богино хугацаанд эрчимтэй сургах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.12. ЗАЛУУЧУУД

- 1.12.1. Залуучуудын хөгжлийн төв байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.12.2. Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.12.3. Технологийн шийдэл ашиглаж, нийгэмд тулгамдсан хэрэгцээ, шаардлагыг шийдвэрлэж буй хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.12.4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, илүү үр дүнтэй хэлбэрээр шинэчлэн зохион байгуулна.

1.13. ЗАЛУУ ГЭР БҮЛ

- 1.13.1. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох “Монгол гэр бүл” боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.13.2. Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой

уялдуулан хэрэгжүүлнэ.

- 1.13.3. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлогыг шинэчлэн, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд эцэг, эхтэйгээ хамт хүмүүжин төлөвших хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.

1.14. АХМАДУУД

- 1.14.1. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар алслагдсан бүс нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.
- 1.14.2. Ахмадын сургалтын төв байгуулж, дахин ур чадваржуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.14.3. Ахмадын эрүүл мэндийн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.14.4. Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны газар байгуулахыг дэмжиж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

1.15. ӨРХ ТОЛГОЙЛСОН ИРГЭД: ЭХ, ЭЦЭГ

- 1.15.1. Өрх толгойлсон эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.16. ГАДААДАД СУРЧ, АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БАЙГАА ИРГЭД

- 1.16.1. Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон орон нутагтаа эргэн ирж буй залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.16.2. Гадаадад ажиллаж байгаа иргэдийн мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.17. ОРОН СУУЦ, ГЭР ХОРООЛОЛД АМЬДАРДАГ ИРГЭД

- 1.17.1. Хот, хөдөөгийн болон гэр хорооллын иргэдийг хувийн орон сууцтай болгох чиглэлээр хувийн хэвшлийн оролцоог хангаж ажиллана.
- 1.17.2. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.
- 1.17.3. Дугуйн болон явган алхалтын замын сүлжээг нэмэгдүүлж, мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэнэ.
- 1.17.4. Авто замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, зогсоолын хүрэлцээг шийднэ.

1.18. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ АЖИЛЛАГСАД

- 1.18.1. Орон нутагт аялал жуулчлалын салбарыг бүх талаар дэмжин ажиллана.
- 1.18.2. Аялал жуулчлалын салбарын ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлнэ.
- 1.18.3. Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулна.

ХОЁР. БОЛОВСРОЛТОЙ АРХАНГАЙ

2.1. ЦОГЦ БОЛОВСРОЛ

XXI зууны өрсөлдөх чадвар бүхий шинэ хүнийг бий болгохуйц, хүний төрөлхийн давуу талд түшиглэсэн боловсролын монгол загварыг хэрэгжүүлнэ.

Боловсролын монгол загварыг дэлхийн боловсролын шилдэг практик, нотлогдсон сайн туршлагуудыг өөрийн онцлог, давуу талуудаар цааш баяжуулан хөгжүүлсэн, одоо хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэх суурь реформын шинжтэй, ирээдүйн сорилтуудыг давахуйц, хангалуун сайхан амьдрах эрхийг баталгаажуулсан, ардчиллын үнэт зүйлс, үндэсний өв уламжлалыг агуулсан байна.

2.1.1. Боловсролын их шилжилт ба хүртээмж

- 2.1.1.1. Цахим шилжилтийг бүрэн хэрэгжүүлж, боловсролын сургалтын

байгууллагууд сургалтыг танхим ба цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлнэ.

- 2.1.1.2. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрд компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэх санал, санаачилгыг дэмжинэ.
 - 2.1.1.3. Ерөнхий боловсролын сургалтын гол зорилго нь эх оронч монгол хүнийг бэлтгэх явдал хэмээн үзэж, монгол хэл, уран зохиол, түүхийн хичээлийн цагийг нэмж, чанаржуулна.
 - 2.1.1.4. Ерөнхий боловсролын сургалтын агуулгыг эх оронч, шинжлэх ухаанч, амьдрах чадвартай монгол хүн бэлтгэх шаардлагад нийцүүлэн шинэчилнэ.
 - 2.1.1.5. Эрүүл амьдралын үндэс нь эрүүл мэндийн мэдлэг, зөв дадал хэвшил хэмээн үзэж, эрүүл мэнд, эрүүл ахуйн хичээлийг нэмж оруулна.
 - 2.1.1.6. Амьдрах чадварыг чухалчлан сургуулиудын материаллаг бааз, сургалтын арга технологийг шинэчлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 2.1.1.7. Зайны сургалтыг хөгжүүлнэ. Зайны цахим сургалтаар ерөнхий болон дээд боловсрол эзэмших боломжийг бүрдүүлнэ.
 - 2.1.1.8. Ерөнхий боловсролын сургуулиудад “Цахим боловсрол” арга хэмжээ хэрэгжүүлнэ.
 - 2.1.1.9. Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн, Монгол хүний онцлогт тохирсон зан чанар, хүмүүжил, сургалтын арга хэмжээг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.
 - 2.1.1.10. Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг жил бүр хийж, боловсролын чанарт ахиц гаргана.
 - 2.1.1.11. Сургууль, цэцэрлэг бүрд ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулахыг дэмжинэ.
 - 2.1.1.12. Хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
 - 2.1.1.13. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, бүх насны иргэд тасралтгүй суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 2.1.1.14. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 2.1.1.15. Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулж, суралцагчдын шүүлтүүртэй цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.
 - 2.1.1.16. Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
 - 2.1.1.17. Сургууль, цэцэрлэгийн урлаг, биеийн тамирын заалны орчин нөхцөлийг сайжруулна.
- 2.1.2. Сургуулийн өмнөх боловсрол**
- 2.1.2.1. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл, соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох хөтөлбөрийг сэргээн сайжруулж, үргэлжлүүлнэ.
 - 2.1.2.2. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг жил бүр нэмэгдүүлнэ.
 - 2.1.2.3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын хөгжлийг дэмжсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ.
 - 2.1.2.4. Сургуулийн өмнөх боловсролын багш нарийг давтан сургах мэргэшүүлэх сургалтад хамруулах.
- 2.1.3. Бага, дунд боловсрол**

- 2.1.3.1. Малчин өрхийн бага ангийн хүүхдийг багийн бага сургууль болон гэрээр хослон сургах “гэрт ойр” тогтолцоо нэвтрүүлнэ.
- 2.1.3.2. Хичээлээс гадуурх сургалт, дугуйлангийн хамрагдалтыг 75 хувьд хүргэж, суралцагчийн сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөтгөнө.
- 2.1.3.3. Билиг авьяасыг дэмжих дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.1.3.4. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын хоцрогдлыг 50 хувиар бууруулна.
- 2.1.3.5. Суралцагчдад хичээлээр дамжуулан суралцахуйд сургах, амьдрах ур чадварт бэлтгэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.1.3.6. Боловсролын чанарын ялгааг арилгах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.4. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

- 2.1.4.1. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг дэмжиж эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан ур чадвартай боловсон хүчнийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.4.2. Техник мэргэжлийн боловсрол олгох сургалтыг чанаржуулж, монгол хэл, түүх соёл, англи хэлний сургалтаар баяжуулна.

2.1.5. Дээд боловсрол

- 2.1.5.1. Насан туршийн боловсролыг дэмжиж, хоёр, гурав дахь мэргэжил эзэмшихийг дэмжинэ. Их, дээд болон техник мэргэжлийн сургуулиудад хос мэргэжил эзэмших хөтөлбөрүүдийг дэмжинэ. Англи хэлний боловсролыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.5.2. Их, дээд сургууль төгссөн залуучуудыг ажиллах орчинд бэлтгэх сургалтыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.5.3. Оюутан, сурагчдыг сургалтын төлбөрийн гэнэтийн өсөлтөөс хамгаалах эрх зүйн бодлогыг дэмжинэ ажиллана.

2.1.6. Багшийн мэргэжлийн хөгжил

- 2.1.6.1. Багш нарыг дэлхийн нэр хүндтэй их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт суралцах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, сайн туршлагыг судлахад бүх талаар дэмжиж ажиллана.
- 2.1.6.2. Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.1.6.3. Бага ангийн багшийн хөдөлмөрийн үнэлэмжийг эрс сайжруулна.
- 2.1.6.4. Багш, суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын цахим лаборатори, видео хичээл, е-сурах бичиг, онлайн сургалт, виртуал орчин бүхий сургалтын нээлттэй тогтолцоог дэмжинэ.
- 2.1.6.5. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэн, мэргэжлийн стандартыг нэвтрүүлж, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэн, тэтгэвэрт гарсан ахмад багш нарыг боловсролын салбарт зөвлөхөөр ажиллуулахыг дэмжинэ.

2.1.7. Шинжлэх ухаан

- 2.1.7.1. Эдийн засгийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж, нутагшуулсан аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.7.2. Хувийн хэвшлийн судалгаа, хөгжүүлэлт болон инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.

2.2. ЭРҮҮЛ МЭНД – ЭРХЭМ БАЯЛАГ

Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, нас баралт болон эх, нярайн эндэгдлийг бууруулж, бүх нийтийн эрүүл мэндийн нэгдсэн цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ. Иргэдийг эрүүл байлгах шинэчлэл хийхдээ өвдөхөөс өмнө урьдчилан сэргийлэхэд болон эрүүл мэндийн боловсролыг сайжруулахад түлхүү анхаарч

ажиллана.

2.2.1. Нийгмийн эрүүл мэнд

- 2.2.1.1. Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчлөл, нас баралтыг 35 хувиар бууруулж, урьдчилан сэргийлнэ.
- 2.2.1.2. Агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын замын халдварт өвчнийг 30 хувиар бууруулна.
- 2.2.1.3. Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог сайжруулан транс тос, сахар, далд давсны хэмжээг бууруулна.
- 2.2.1.4. Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүнийг хязгаарлах хууль, эрх зүйг хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.1.5. Гэмтэл, ослыг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлж, нийт нас баралтын хэмжээг эрс бууруулна.
- 2.2.1.6. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.
- 2.2.1.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.2.1.8. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

2.2.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

- 2.2.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, эмнэлгийн бие даасан, хүртээмжтэй байх бодлогыг бүрдүүлэн ажиллана.
- 2.2.2.2. Яаралтай, түргэн тусламжийн үйлчилгээг тэлж, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шилжүүлэх замаар иргэдэд ойр болгоно.
- 2.2.2.3. Явуулын эмнэлгийн тоог нэмэгдүүлж чанаржуулахад анхаарч, өрх, сум, багийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 2.2.2.4. Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийж улсын чанартай авто зам дагуух шаардлагатай цэгүүдэд яаралтай тусламжийн төв байгуулах замаар яаралтай тусламжийн хүртээмжийг сайжруулна.
- 2.2.2.5. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдийг орчин үеийн шаардлагад нийцсэн техник тоног төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд орон нутагтаа оношлогдон эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.2.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж ажиллана.
- 2.2.2.7. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 2.2.2.8. Хавдрын эрт илрүүлнэгийн төвийн үйл ажиллагааг эхлүүлж, хавдрын эрт илрүүлэлтийг зохион байгуулна.
- 2.2.2.9. Сумдад шүдний кабинет байгуулна.

2.2.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал

- 2.2.3.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл, түүний хяналттай холбоотой хуулийн хэрэгжилтийг хангаж эмийн үнэ чанар зохистой хэрэглээ хүртээмжийн бодлогыг хэрэгжүүлж ажиллана. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах хяналтын цахим тогтолцоонд шилжинэ.

2.2.4. Чадамжтай мэргэжилтэн

- 2.2.4.1. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн бодлого, сонгон шалгаруулалт, урамшуулал, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинээр бүрдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээг үйлчлүүлэгчдийн оролцоотой, ил тод, шударга болгоно.
- 2.2.4.2. Эмч нарын ажил, үйлчилгээний мэдээллийн санг бий болгож, ил тод, шударга, өрсөлдөөнд суурилсан тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ. 38 төрлийн программыг нэгтгэж, давхардлыг арилгана.
- 2.2.4.3. Өрх, сумын эрүүл мэндийн төвд ажиллах эмчийг бодлогоор дэмжиж, тоог

нэмэгдүүлнэ.

- 2.2.4.4. Эмнэлгийн мэргэжилтний цалин, урамшуулал, хангамжийг ажлын ачаалал, мэргэжлийн онцлог, орон нутгийн алслагдмалтай уялдуулан нэмэгдүүлэх эрх зүйн бодлогыг дэмжин ажиллана.

2.2.5. Цахим эмнэлэг

- 2.2.5.1. "Цахим эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоонд шилжинэ.
- 2.2.5.2. Алсын зайн оношилгоо, үйлчилгээ (телемедицин)-г шинэ түвшинд гаргаж, хөгжүүлнэ.
- 2.2.5.3. Эрүүл мэндийн даатгалын цахим технологийг нэвтрүүлж, өвчтөнд эмнэлгээ сонгох эрхийг олгоно.

2.2.6. Эрүүл мэндийн оновчтой санхүүжилт

- 2.2.6.1. Эрүүл мэндийн даатгалын стратегийн худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх бодлого баримталж, иргэн бүр хяналт тавих цахим системийг бий болгоно.
- 2.2.6.2. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн өртгийг тооцож, эрсдэлийн үнэлгээг тогтмолжуулна.
- 2.2.6.3. Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж, тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.
- 2.2.6.4. Төрийн эмнэлгийн зарим үйлчилгээг хувийн хэвшлийн эмнэлгээр, гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн бодлогыг дэмжинэ.

2.2.7. Монголын уламжлалт анагаах ухаан

- 2.2.7.1. Уламжлалт анагаах ухааны анхан шатны эрүүл мэндийн болон нийтийн эрүүл мэндийн салбарт эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

2.2.8. БИЗНЕС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 2.2.8.1. Бизнес, хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжиж, дундаж давхаргын эгнээг тэлнэ.
- 2.2.8.2. Ажилгүйдлийн түвшинг 5 хувиас бага түвшинд байлгах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.8.3. Цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.
- 2.2.8.4. Хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд оролцогч талуудын эрх ашгийн тэнцвэрийг хангах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.
- 2.2.8.5. Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.2.8.6. Ажил олгогчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бүрэн хангах мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.8.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалтыг харилцан уялдуулсан ослын даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 2.2.8.8. Инновацид суурилсан гарааны бизнесийг дэмжинэ. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлнэ.
- 2.2.8.9. Хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулж, ясли, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.8.10. Байгалийн дагалдах баялаг, мал аж ахуй, газар тариалан болон гахай, тахиа, зөгий зэрэг аж ахуйд суурилсан орон нутгийн онцлогийг шингээсэн,

шинэ брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

2.2.8.11. Орон нутгийн түүхий эд нөөцөд тулгуурласан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.2.8.12. Гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

ГУРАВ. ӨМЧТЭЙ АРХАНГАЙ

Иргэн хүн өмчтэй байх, өмчдөө бүрэн эрхт эзэн нь байх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ ИРГЭН

3.1.1. Хүний заяагдмал эрхийг хамгаалах, иргэдэд хүний эрхийн талаар ойлголт өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.

3.1.2. Хувь хүний нууц, халдашгүй байдлыг хамгаалах зорилгоор гэрийн хаяг, регистрийн дугаар, гэр бүлийн байдал зэрэг хувийн мэдээллийг хэзээ, хэнд, хэрхэн олгохыг хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд хувь хүн өөрөө сонгох эрхийг бүрдүүлж, энэ төрлийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад задруулах, задруулахаар сүрдүүлэхээс хамгаалах эрх зүйн бодлогыг дэмжинэ.

3.1.3. Сэтгүүлчийг хэвлэн нийтэлснийх нь төлөө хорьж, цагддаггүй хууль, эрх зүйн бодлогыг дэмжинэ.

3.1.4. Олон нийтийн сүлжээнд иргэний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

3.2. ӨМЧТЭЙ ИРГЭН

3.2.1. Монгол хүн өмчтэй байх, өмчдөө бүрэн эрхт эзэн нь байх нөхцөлийг сайжруулсан хуулийг хэрэгжүүлж ажиллана.

3.2.2. Газар эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн бодлогыг дэмжин ажиллана.

3.2.3. Хувь хүн, өрх гэр баялаг бүтээх талбарт хамтран ажиллагсдын ашиг сонирхлын нийтлэг харилцаанд төрийн оролцоо, дарамт, шахалтыг хязгаарлана.

3.2.4. Хэрэглэгчийн эрх ашгийг хангах зорилгоор эдийн засгийн оролцоотой, хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн бодлого, татварын болон тарифын зохицуулалт, хувь хүний санаачилга, бизнес эрхлэх боломж, нийгмийн хариуцлагатай аж ахуй эрхлэлт, бие даасан зохицуулалтыг дэмжиж, хөгжүүлнэ.

3.2.5. Өмчийн эрхийг баталгаажуулж, хувийн өмчийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.3. ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН ХӨТӨЛБӨР

3.3.1. "Хариуцлагатай монгол хүн" хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрт дараах хариуцлагын үзүүлэлтүүдийг тусган хэрэгжүүлнэ:

- Нийгэм, улс төрийн үйл ажиллагаанд, тухайлбал улс төрийн сонгуульд идэвхтэй оролцох, нийгмийн сайн сайхны төлөө ажиллах;
- Байгаль орчинд ээлтэй хандах, жам ёсоор нь хадгалах, сэргээх, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах, байгалийн нөөц, ялангуяа цэвэр усны нөөцөд ариг гамтай хандагч байх;
- Олон талын мэдээлэлд дүн шинжилгээ хийж чаддаг, бодит мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурласан дүгнэлт гаргах чадвартай байх;
- Ардчилал, улс төр, засаглалын хөгжил, түүхийн мэдлэгээр өөрийгөө баяжуулах, насан туршдаа сурч боловсрох, иргэний боловсролоор өөрийгөө хөгжүүлэгч байх;
- Ардчиллын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, бүх шатны

сонгуульд саналаа өгөх, Улсын Их Хуралд сонгогдсон гишүүд, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон төлөөлөгчдөөр дамжуулан саналаа илэрхийлдэг байх.

3.4. АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ ИРГЭН ХӨТӨЛБӨР

- 3.4.1. Кибер халдлагатай тэмцэх, иргэний цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.4.2. Эрсдэл бүхий газруудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох “ногоон бүс” буюу аюулгүй бүс бий болгох ажлыг дэмжинэ.
- 3.4.3. Нийтийн эзэмшлийн зам, талбай дахь камержуулалтын ажлыг суурилуулах журам, эрх зүйн баримт бичгийг боловсруулахад хувь хүний нууцыг хадгалахтай холбоотой асуудлыг анхаарна. “Манаачийг манах” буюу мэдээллийн дататай ажиллаж буй эрх бүхий албан тушаалтныг хянах технологийн шийдлийг нэвтрүүлнэ.
- 3.4.4. Авлигын эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.4.5. Хувь хүний орон байрны халдашгүй байдлыг хамгаалах эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. БҮТЭЭЛЧ АРХАНГАЙ.

Худалдаа, аж үйлдвэр, уул уурхай, боловсруулах үйлдвэр, тээвэр, хоол хүнс, мэдээлэл харилцаа, санхүү, даатгал, нийгмийн хамгаалал, соёл, урлаг, аялал жуулчлалын зэрэг салбар бүрийн бодлогыг оновчтой тодорхойлж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэнэ.

4.1. ХУДАЛДААНЫ САЛБАР

- 4.1.1. Худалдааны тухай хуулийг хэрэгжүүлж, худалдаа эрхлэгчдийн эрх ашгийг хамгаална.
- 4.1.2. Эдийн засгийн түншлэл болон чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар гадаад худалдааг олон тулгууртай болгоно.
- 4.1.3. Гадаадын зарим улс орнуудтай иргэн аж ахуйн нэгжүүд худалдаа хийхийг дэмжинэ.
- 4.1.4. Хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааг эрчимжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 4.1.5. Эдийн засгийн чөлөөт бүсэд бизнес инкубатор төв байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.

4.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

- 4.2.1. Шинээр бизнес эрхэлж буй иргэдийг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.3. Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.
- 4.2.4. Нано технологи, био технологи, өндөр технологи нэвтрүүлж, нутагшуулсан, инновац шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг татварын болон хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжинэ.
- 4.2.5. Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацид суурилсан дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

- 4.2.6. Төрийн худалдан авалтыг үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээл дэх борлуулалтыг дэмжихэд чиглүүлнэ.

4.3. УУЛ УУРХАЙН САЛБАР

- 4.3.1. Бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.
- 4.3.2. Уурхайн үйл ажиллагааны хяналт, нөхөн сэргээлт, хаалтын стандартыг олон улсын жишигт хүргэж, дүйцүүлсэн нөхөн сэргээлтийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 4.3.3. Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжбүрэн хариуцан гүйцэтгэдэг болгоно.
- 4.3.4. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гэрээ, хэлэлцээрийг төрийнбүх шатанд байгуулж, үр дүн гаргана.
- 4.3.5. Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв, тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог шинэ шатанд гаргана.

4.4. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

- 4.4.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоог бий болгох, олон улсын стандартыг нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.4.2. Хэрэгжиж байгаа бүтээн байгуулалтын төслүүдийг үргэлжлүүлнэ. Техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, санхүүжилт шийдэгдсэн, богино хугацаанд үр ашиг өгөх төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.
- 4.4.3. Эрдэс баялгийн болон малын гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажиллана.
- 4.4.4. Сум бүрийн онцлогт тохирсон малын гаралтай мах махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, яс, дайвар бүтээгдэхүүн, хөөвөр, хялгас, эвэр туруу, мод модон бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, малын тэжээл боловсруулах үйлдвэрүүдийг бодлогоор дэмжинэ.

4.5. ТЭЭВРИЙН САЛБАР

- 4.5.1. Монгол Улсын зам, тээврийн салбарын болон тээврийнлогистикийн бодлогыг нэгтгэсэн Тээврийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана.
- 4.5.2. Тээврийн салбарт дэвшилтэт техник технологи, инновац, дижитал шилжилтийг нэвтрүүлж, тээвэрлэлтийн аюулгүй, найдвартайбайдлыг хангана. Замын сүлжээнд ухаалаг систем нэвтрүүлнэ.
- 4.5.3. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарыг түшиглэсэн тээвэр, логиستيкийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- 4.5.4. Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг чөлөөт өрсөлдөөнд шилжүүлж, дагаж мөрдөх стандартыг сайжруулна.

4.6. ХООЛ, ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

- 4.6.1. Хүнсний захуудад баримталдаг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг мөрдөн ажиллана.
- 4.6.2. Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад чиглэгдсэн хүнсний стандартыг шинэчлэн тогтооно.
- 4.6.3. Суурь хэрэгцээний хүнсийг дотооддоо үйлдвэрлэх аж ахуйн

нэгжүүдийн санал, санаачилгыг дэмжинэ.

- 4.6.4. Мэдлэг, технологийн дэвшил, инновац шингэсэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжин өрсөлдөх чадварыг сайжруулж, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 4.6.5. Жимс, жимсгэнэ, нарийн ногоо тариалах болон хүлэмжийн газар олгох, ашиглахад уян хатан бодлого баримталж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

4.7. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАР

- 4.7.1. Шуудангийн хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг нэмэгдүүлнэ.
- 4.7.2. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, аж үйлдвэрийн инновацийн эрин үеийн технологийн дэвшлийг бүх шатанд ашиглах боломжийг нэмэгдүүлнэ.
- 4.7.3. Орон нутагт өндөр хурдны шилэн кабелийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.7.4. Инновацид суурилсан гарааны бизнесүүдийг дэмжиж, экосистемийг бүрдүүлнэ.
- 4.7.5. Боловсролын байгууллагуудын нэгдсэн сүлжээг байгуулна.

4.8. САНХҮҮ, ДААТГАЛЫН САЛБАР

- 4.8.1. Хөрөнгийн зах зээлийн зөөлөн болон хатуу дэд бүтцийг гадаад зах зээлд нийцтэйгээр бүрдүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.8.2. Засаглалыг сайжруулах, нягтлан бодох бүртгэл, аудитын чанар, хяналт, шалгалтын үр дүнтэй арга хэлбэрийг хэрэгжүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.
- 4.8.3. Банк, санхүүгийн байгууллагаас олгох зээлийн төрөл, салбар, нөхцөлийг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулна.
- 4.8.4. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн, өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг ашигласнаар иргэн, аж ахуйн нэгжид бий болох ашгийн бодит хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

4.9. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР

- 4.9.1. Халамжийг нэмэгдүүлэх бус, ажил хөдөлмөр, бизнес эрхэлж байгаа иргэдийг дэмжих бодлого баримтална.
- 4.9.2. Нийгмийн халамжийн хөтөлбөрт үр нөлөөний үнэлгээ хийж, халамжид хамрагдах шалгуур, нөхцөлийг оновчтой болгоно.
- 4.9.3. Нийгмийн халамжийн нийтлэг мөнгөн тэтгэмж, тусламжийн төрлийг цөөлж, ядуу, зорилтот өрх, иргэнд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.9.4. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн халамжийн хөтөлбөрүүдийг төгсөх хугацаатай болгоно. Халамжийн хөтөлбөрөөр дамжуулан хөдөлмөр эрхлэх сэдлийг бий болгож, шаардлагатай тохиолдолд хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх, өрх, иргэнийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.9.5. Нийгмийн халамжийн салбарын боловсон хүчний хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн удирдлагын тогтолцоог бий болгоно. Ажилтнуудыг мэргэшүүлэхээс гадна мэргэжлийн нийгмийн ажилтан, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн орлолцоог нэмэгдүүлнэ.
- 4.9.6. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийг баг, сум, аймгийн түвшинд тодорхой зорилт, шалгуур үзүүлэлтээр гаргаж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулна.
- 4.9.7. Бага орлоготой, ядуу өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар эзэмшүүлэх хөтөлбөрт хамруулан ажиллана.
- 4.9.8. Байгалийн гамшиг, үер, зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх,

- гамшгийн үед авах арга хэмжээний талаарх халамжийн хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.9.9. Нийгмийн хамгааллын салбарыг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй болгоно.
- 4.9.10. Тусгай хэрэгцээт 0-16 насны хүүхдээ асран ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эх /эцэг/-ийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс төлөх бодлогыг дэмжиж ажиллана.
- 4.9.11. Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоож, зорилтод бүлгийн өрхийн гишүүдийн эрэлт, санаачилга, боломжид тулгуурлан өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.
- 4.9.12. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-ийг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд сэтгэл заслын болон сэргээн заслын иж бүрэн үйлчилгээ үзүүлнэ.

4.10. СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАР

- 4.10.1. Нүүдлийн ахуйд суралцах, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх аргахэмжээ, хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 4.10.2. Биет бус соёлын өвийг бүртгэж, хадгалах зорилгоор дүрс бичлэг бүхий дижитал архив үүсгэнэ.
- 4.10.3. Түүх, соёлын дурсгалт газруудын виртуал бодит аяллыг хөгжүүлнэ.
- 4.10.4. Соёлын дурсгалыг хамгаалах төслийг дэмжих мэдээллийн нэгдсэн цахим платформыг бий болгоно.
- 4.10.5. Төрийн өмчит соёл, урлагийн газруудын үйл ажиллагааг улирлын чанарт тохируулан алдагдалгүй ажиллах боломжийг бүрдүүлнэ.
- 4.10.6. Соёлын биет болон биет бус өвийн цахим санг бүрдүүлж, соёлын өвийг өвлөн уламжлуулах, сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- 4.10.7. Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлаж хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
- 4.10.8. Музейн үйл ажиллагааг өргөжүүлж, сан хөмрөгийг баяжуулан, музейд виртуал орчин бий болгоно.
- 4.10.9. Орхон-Тамир, Хануй-Хүнүйн дурсгалыг түшиглэн "Төв Азийн түүх соёлын голомт судалгаа, сурталчилгаа, хамгаалалтын цогцолбор"-ыг, Зая гэгээний хийдийг түшиглэн "Төв Монголын байгаль-түүх-соёлын цогцолбор музей"-г тус тус байгуулна.
- 4.10.10. Соёл урлагийн байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр ханган, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.
- 4.10.11. Үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 4.10.12. Хүүхэд залуучуудад өв соёл, зан заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, эх оронч үзэл, үндэсний бахархлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, Монгол хэл, бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 4.10.13. Нүүдлийн соёл иргэншлийн суурь дээр тулгуурласан мэргэжлийн урлагийг хөгжүүлэн, үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий соёлын брэндийг бий болгож, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ.
- 4.10.14. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.10.15. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Нийтийн биеийн тамир, спорт

- 4.10.16. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлж, хүн амыг хөдөлгөөний

дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөв, дадал хэвшилтэй болгох үйл ажиллагааг идэвхжүүлнэ.

- 4.10.17. Үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайг хүүхэд залуучуудад өвлөн уламжлуулахыг дэмжиж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.
- 4.10.18. Өсвөр, залуучууд, паралимпийн шигшээ багийг шинэчлэн байгуулж, улс, тив дэлхийн хэмжээний тамирчин бэлтгэх, үндэсний хэмжээний тэмцээнүүдийг орон нутагт зохион байгуулахад спортын холбоод, клубтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.
- 4.10.19. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэн, цэнгэлдэх хүрээлэнг тохижуулж ашиглалтыг сайжруулна.

4.11. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 4.11.1. “Шүршүүр - жорлон” хөтөлбөрийг тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станц болон өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний дэлгүүрүүдэд санал болгож, хамтран хэрэгжүүлнэ.
- 4.11.2. “Сэрүүн Монгол” аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 4.11.3. Жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 4.11.4. Аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 4.11.5. Аялал жуулчлалын хувийн зөвлөгч гаргахын тулд хиймэл оюун ухаан ашигласан платформ нэвтрүүлнэ.
- 4.11.6. Спорт, эрүүл мэнд, явган алхалт, эко туризм зэрэг нүүдэлчний өв соёлыг сурталчлах аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг бодлогоор дэмжинэ.
- 4.11.7. Аялал жуулчлалын салбарын тээврийн эрэлт хэрэгцээг хангахын тулд авто зам, агаарын замын хүчин чадлыг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох уян хатан бодлого хэрэгжүүлнэ.
- 4.11.8. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг бодлогоор дэмжинэ.
- 4.11.9. “Цахим аялал жуулчлал” арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 4.11.10. Архангай аймгийг “Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв” болгон хөгжүүлэх төлөвлөгөө /2024-2034/ дунд хугацааны арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.11.11. Архангай аймгийн Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.11.12. Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулан, сургалт, мэдээллийн төвд цахим технологийг нэвтрүүлж, гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлнэ.
- 4.11.13. Архангай аймгийн тахилгат, шүтлэгт газруудыг бүртгэл мэдээллийн санд оруулна.
- 4.11.14. Уламжлалт хэл, соёл, ёс заншлаа хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, нутгийн иргэд, нүүдлийн соёлд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Нүүдэлчдийн соёл”-ын арга хэмжээг жил бүр зохион байгуулж, дотоод, гадаадын жуулчдад сурталчилна.
- 4.11.15. Ялгамж төрх бүхий аймгийн аялал жуулчлалын брэндингийг бүтээнэ.

ТАВ. ӨРИЙН ДАРАМТГҮЙ АРХАНГАЙ

Архангай аймгийн хөгжлийг дэмжих үр ашигтай дэд бүтцийг орчин үеийн стандартад нийцүүлэн бүтээн байгуулах нь Ардчилсан намын зорилтуудын нэг байх болно. Үүний тулд төсвийн оновчтой шийдвэр гаргаж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хослуулан хэрэгжүүлнэ.

Архангай аймгийн эдийн засаг илүү тогтвортой, хуримтлалд

суурилсан эрүүл өсөлтөөр урагшлах эдийн засгийн бие даасан бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1. ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

- 5.1.1. Төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- 5.1.2. Татвар төлөгчийн суурийг өргөжүүлэх замаар төсвийн орлого тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.1.3. Төрийн өмчит компаниудын засаглалыг сайжруулж, нээлттэй, олон нийтийн оролцоотой болгон хувьчлах замаар өгөөжийг нэмэгдүүлж, бүрдүүлсэн орлогыг өрийн дарамтыг бууруулахад зарцуулна.
- 5.1.4. Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.
- 5.1.5. Төрийн албаны давхардлыг арилгаж, цомхон бүтцээр ажиллана.
- 5.1.6. Төрийн албанаас хувийн салбарт шилжин ажиллахыг дэмжсэн эдийн засгийн хөшүүргүүдийг ашиглана.
- 5.1.7. Дижитал эдийн засаг, цахим худалдааны шинэ, ухаалаг (смарт) үйлчилгээг бий болгож, эдийн засгийн голлох тулгуур болгоно.
- 5.1.8. Старт-ап бизнес эрхлэгчдийг урамшуулах, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мэдээллийн технологийн үйлчилгээний экспортыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.1.9. Орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний худалдан авалтад дотоодын аж ахуй нэгж үйлдвэрлэл эрхлэгчдийг тэргүүн ээлжид дэмжих бодлогыг баримтлан, худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэд, төрийн бус байгууллагын хяналтын дор ил, тод нээлттэй зохион байгуулна.
- 5.1.10. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулж, хэмнэлтийн горимыг баримтлан, төсвийн ил тод, шилэн байдлыг хангаж ажиллана.
- 5.1.11. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх замаар иргэдийн орлогыг өсгөж, хуримтлалтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

5.2. ТАТВАРЫН БОДЛОГО

- 5.2.1. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.
- 5.2.2. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлдэг тодорхой салбаруудад татварын тодорхой бодлого хэрэгжүүлнэ.
- 5.2.3. НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлнэ.

5.3. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 5.3.1. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулан аймгийн нэр хүндийг өсгөж, гадаадын хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.
- 5.3.2. Экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, үндэсний бүтээгдэхүүн үйлчилгээний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- 5.3.3. "Дижитал нүүдэлчин" визээр ирсэн хөрөнгө оруулагчдыг дэмжинэ ажиллана.
- 5.3.4. Гадаадын хөрөнгө оруулагчдад тавигдах шалгуур үзүүлэлт, хөрөнгө оруулалтын хэмжээг тогтоосон хуулийг хэрэгжүүлж ажиллана.

5.4. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮД

- 5.4.1. Аж үйлдвэрийн салбарт дэвшилтэт техник, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аймгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлнэ.
- 5.4.2. Оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахыг бодлогоор дэмжинэ.
- 5.4.3. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн бодлогыг

дэмжинэ ажиллана.

- 5.4.4. Зээлийн батлан даалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлнэ.
- 5.4.5. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.
- 5.4.6. Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх, кластерийн талаар баримтлах стратегийг боловсруулна.
- 5.4.7. Хөдөө аж ахуй, уул уурхайн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар хөгжүүлнэ.
- 5.4.8. Боловсруулах үйлдвэрүүдэд шаардлагатай эрчим хүч, ус, зам, тээврийн дэд бүтцүүдийг ээлж дараатай бий болгоно.
- 5.4.9. Одоо ашиглаж байгаа ашиглахад бэлэн байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 5.4.10. Бордооны үйлдвэрийг барихыг дэмжинэ.
- 5.4.11. Ноос боловсруулах үйлдвэрийг сэргээж, ноосон эдлэл, бүтээгдэхүүн, ялангуяа шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг дэмжинэ.

5.5. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА

- 5.5.1. Барилгын салбарт шинэ инновацлаг бараа материал, угсралтын арга барилыг хурдацтай нэвтрүүлэх зорилгоор EN, ISO зэрэг олон улсын стандартуудыг шууд ашиглахыг зөвшөөрнө.
- 5.5.2. Барилга, орон сууцны ашиглалтыг сайжруулж, СӨХ-ны үйл ажиллагааны үндсэн зарчим, суурь зохион байгуулалтыг зах зээлийн эдийн засгийн харилцааны механизмд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулна.
- 5.5.3. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн үр өгөөжтэй, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан шинэ технологийн халаалт, дэд бүтцийн системийг нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 5.5.4. Нийтийн орон сууцны ашиглалтын хүрээнд төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллага болон СӨХ-дын түншлэлд шилжүүлэх журмаар засвар, үйлчилгээний, инженерийн хангамжийн асуудлуудыг өмчлөгч өөрөө хариуцах чадамжийг бэхжүүлж, төрийн оролцоог багасгана.
- 5.5.5. Амины орон сууцны болон хуучин орон сууцны дулаан алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 5.5.6. Иргэний аюулгүй, эрүүл орчинд амьдрах эрхийг баталгаажуулах хүрээнд нийтийн орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжтай ойролцоо шатахуун түгээх станц болон хийн түлшний түгээгүүр байрлуулахыг хориглоно.
- 5.5.7. Гэр хорооллын дэд бүтцийг шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.5.8. Аймаг, сумын газар зохион байгуулалт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.
- 5.5.9. Олон улсын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүдийг дэмжин, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгоно.

Бүтээн байгуулалт

- 5.5.10. Аймгийн төвийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
- 5.5.11. Аймгийн төвийн цэвэр усан хангамжийн эх үүсвэрийг 70 хувиар нэмэгдүүлнэ;
- 5.5.12. Аймгийн төвийн бохир ус ариутгах татуургын хүчин чадлыг 70 хувиар нэмэгдүүлж, олон дахин ашиглалтын горимд шилжүүлнэ.
- 5.5.13. Хүн амыг орон сууцжуулах зорилтын хүрээнд дараах чиглэлээр орон сууцны бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.5.14. "Тогтвортой орлого бүхий орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймаг, сумын төвүүдэд орон сууцыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байршилтай

уялдуулан хүн амын зорилтот бүлэгт тааламжтай нөхцөлөөр бүтээн байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ;

5.5.15. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд түрээсийн орон сууцны фонд бий болгоно.

5.5.16. Хашаандаа амины тохилог орон сууц барих санаачилгыг бодлогоор дэмжинэ.

5.5.17. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор сумдын ерөнхий төлөвлөгөө, зураг төслийг иргэдийн оролцоонд тулгуурлан боловсруулж, дэд бүтэцжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

5.6. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

5.6.1. Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.6.2. Хөдөө аж ахуй, хүнсний нийлүүлэлтийн сүлжээний үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт, хэрэглээний үе шатанд мөшгөх технологи, олон улсын зохистой дадал, стандартыг хэвшүүлнэ.

5.6.3. Хүн амын хүнсний чанар, шим тэжээлийг сайжруулж, тэнцвэртэй, эрүүл хооллолтын зохистой дадлыг хэвшүүлнэ.

5.6.4. Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

5.6.5. Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны орчныг либералчилж, эко, ногоон, органик шошготой бүтээгдэхүүнийг олшруулан сав баглаа, боодлыг аймгийн нэгдмэл стандарттай болгоно.

5.6.6. Хот, суурин газрын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах стандартыг бүрдүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

5.6.7. Хүнсний аюулгүй байдлын найдвартай статистик мэдээллийн системийг нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний хяналтын тогтолцоог шинэчилнэ.

5.7. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5.7.1. Ус

5.7.1.1. Гэр хорооллын инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэтийн шилэн кабель)-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүжүүлэх бодлогыг дэмжин ажиллана.

5.7.1.2. Эрдэнэбулган суманд дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна.

5.7.1.3. Саарал усны ашиглалтыг нэмэгдүүлнэ.

5.7.1.4. Гүний усыг ариглан гамнах төсөл хэрэгжүүлнэ.

5.7.1.5. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд сум бүрд 50-100 га ногоон байгууламж бий болгоно.

5.7.2. Авто зам

5.7.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа авто замуудын ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

5.7.2.2. Аймгийн төвийн авто замын засвар үйлчилгээг орон нутгийн хөгжлийн сан, авто замын сангийн хөрөнгөөр хийх бодлого хэрэгжүүлнэ.

5.7.2.3. Аялал жуулчлалын бүс дэх Цэнхэрийн халуун ус, цайдмын түрэгийн хөшөөний замыг Өгийнуурын мянганы замтай холбох, Цахир сумын гэгээнтэн 2 багшид хүрэх зам, Цагаан давааны шороон зам зэрэг замуудын ТЭЗҮ зурагт төсийг орон нутгийн хөгжлийн сангаас хийж бэлэн болгох.

5.7.2.4. Орон нутгийн чанартай авто замын шинэчлэл, засвар, үйлчилгээ хийх хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг хангуулна.

5.7.2.5. Авто замын стандартыг хэрэгжүүлж, шинээр баригдах авто замын чанарын хяналтыг сайжруулна.

5.7.3. Эрчим хүч

- 5.7.3.1. Эрчим хүчний салбарт ухаалаг үнийн систем нэвтрүүлнэ.
- 5.7.3.2. Сум бүрийг аваарын бага оврын цахилгаан станцуудтай болгоно.
- 5.7.3.3. Цахилгаан эрчим хүчний тархмал эх үүсвэрийг бий болгох ажлыг дэмжинэ.
- 5.7.3.4. Орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 5.7.3.5. Ногоон эдийн засгийг дэмжсэн сэргээгдэх эрчим хүчний эхүүсвэрийн дэмжинэ.
- 5.7.3.6. Сум, аймгийн төвийн 04-ын шугамын засварыг ээлж дараалалтай хийнэ.

5.7.4. Харилцаа холбоо

- 5.7.4.1. Интернэтийн хүртээмжийг сайжруулна.
- 5.7.4.2. Төрийн байгууллагуудын дата сангуудын өөрчлөлтийг бүртгэж, шилэн болгоно.
- 5.7.4.3. 5G технологи нэвтрүүлнэ.
- 5.7.4.4. Сансарын интернэтийг малчдад бүрэн нэвтрүүлж, мал маллахажилд технологийн ололтыг нэвтрүүлнэ.

5.7.5. Хөдөө аж ахуй

Мал аж ахуйн салбар

- 5.7.5.1. Салбарын хөгжлийн суурь хүчин зүйл болсон бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 5.7.5.2. “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.7.5.3. Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- 5.7.5.4. Малын тэжээлийн үйлдвэрлэлийн бизнес эрхлэхэд чиглэсэн хувийн хэвшлийн санаачилгыг урамшуулан дэмжиж, малын таримал тэжээлийн тариалалтыг малчин өрх бүрд тариалах боломжийг бүрдүүлнэ.
- 5.7.5.5. Өндөр ашиг шимтэй үндэсний болон дасан зохицох чадвартай гадаадын үржлийн малыг өсгөн бойжуулах үржлийн аж ахуйг хөгжүүлж, малчдад чанартай, таваарлаг малтай болох боломжийг дэмжинэ.
- 5.7.5.6. Мах, сүү, шувуу, зөгийнний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэхиргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.
- 5.7.5.7. Мах, махан бүтээгдэхүүний зах зээлийг тэлж, стандартад нийцсэн “Архангай мах” брэнд бий болгон хөгжүүлнэ.
- 5.7.5.8. Малын гаралтай хоёр дахь түүхий эдийг хаягдалгүй боловсруулах, өндөр уургийн агууламжтай түүхий эд үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 5.7.5.9. Өвлийн хүлэмж, мал, амьтны фермийн барилга байгууламжид хөрөнгө оруулалт хийж байгаа аж ахуй нэгжийг дэмжинэ..
- 5.7.5.10. Гахай болон тахиа, өндөгний бизнес эрхлэх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжинэ.
- 5.7.5.11. Малчдын татвар төлөлт, нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хангаж, татварын системд татварын тайлан илгээх аргачлалыг хялбарчлах нэгдсэн системийг хэрэгжүүлнэ. Эрсдэл бүхий нөхцөлөөс урьдчилан сэргийлэх тохиолдол бий болсон үед малчдад худалдан борлуулж, эргэлтэд оруулах зорилготой өвс, тэжээлийн нөөцийн фондыг нэмэгдүүлнэ.
- 5.7.5.12. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх замаар иргэдийн орлогыг өсгөж, хуримтлалтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ.
- 5.7.5.13. “Цахим хөдөө аж ахуй” арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 5.7.5.14. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, сумын болон сум дундын отрын бүс нутгийг тогтоон, бэлчээрийг хамгаалах, хортон мэрэгч устгах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

- 5.7.5.15. Малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулан, генетик нөөцийг хамгаалж, сумдад цөм сүргийн үржүүлэг технологийн нэгж байгуулж, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах арга хэмжээг хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 5.7.5.16. Мал сүргийг бүртгэлжүүлж, гарал үүслийг тодорхой болгон, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлэх, мал, махыг зах зээлд нийлүүлэх мэдээллийн цахим систем хэрэгжүүлнэ.

Газар тариалангийн салбар

- 5.7.8.1. Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх тариаланчид болон төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн эрх зүйн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 5.7.8.2. Усалгаатай тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн ус, эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй техник, технологийн хангамжийг сайжруулж, нэгжээс авах ургацыг дээшлүүлнэ.
- 5.7.8.3. Хүлэмжийн аж ахуй, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ. Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, шинэ ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулна.
- 5.7.8.4. Стратегийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг өргөтгөн цардуул, ургамлын тос, бусад ашигт таримлын тариалалтыг нэмэгдүүлж, салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- 5.7.8.5. Өрхийн тариалан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ЗУРГАА.ТӨРИЙН ДАРАМТГҮЙ АРХАНГАЙ

Аймгийн төвд болон хүн ам төвлөрсөн сумдад иргэдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Аймгийн төвд дулааны цахилгаан станц барьж, шугам сүлжээг шинэчлэх замаар аймгийн төвийн агаарын бохирдлыг үе шаттайгаар бууруулна.

Аймгийн төвд сүү, сүүн бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд, арьсшир, дайвар бүтээгдэхүүний үйлдвэр, сумдад мал нядалгааны болон арьс ширний цех байгуулна.

Аймгийн төвд болон томоохон сум, суурин газруудыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эрчимжүүлж. Аймгийн төвийг дахин төлөвлөж, "гудамж" төслийг хэрэгжүүлнэ.

Аймгийн төв, сумын нүхэн жорлонг бууруулна.

6.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

6.1.1. (Архангай аймаг):

- 6.1.1.1. Цэнхэр суманд эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл хийх.
- 6.1.1.2. Хангай суманд цагаан идээний болон сарлагийн хөөврийн үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.3. Цэнхэр суманд мал нядалгааны цех хөргүүртэй зоорь барихыг дэмжинэ.
- 6.1.1.4. Хотонт сумын хонины ноос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах.
- 6.1.1.5. Төвшрүүлэх суманд гурил тэжээлийн үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.6. Өндөр-Улаан, Чулуут сумдад сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.7. Чулуут сумыг холбох авто замыг ашиглалтад оруулна.
- 6.1.1.8. Эрдэнэбулган суманд хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.9. Сум бүрд хүлэмжийн аж ахуйн, ногоо боловсруулах үйлдвэр, зоорь

барихыг дэмжинэ.

- 6.1.1.10. Аймаг сумын төвийн байр гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг сайжруулна.
- 6.1.1.11. Эрдэнэбулган суманд барилгын материалын үйлдвэрлэлийг байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.12. Цахир сумын ерөнхий боловсролын сургуулийн барилгыг ашиглалтад оруулна.
- 6.1.1.13. Тариат, Цахир, Их-Тамир, Цэнхэр, Өгийнуур сумуудыг аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ
- 6.1.1.14. Их-Тамир суманд мал нядалгааны цех хөргүүртэй зоорь барихыг дэмжинэ.
- 6.1.1.15. Эрдэнэмандал суманд хөдөө аж ахуй үйлдвэрлэл технологийн паркийг өргөжүүлнэ.
- 6.1.1.16. Хайрхан суманд гурил тэжээлийн үйлдвэрийг барихыг дэмжинэ
- 6.1.1.17. Сумын төвүүдийн цэвэр дулааны шугамыг шинээр хийж өргөтгөнө.
- 6.1.1.18. Батцэнгэл, Цэнхэр, Булган, Их-Тамир сумдад эрчимжсэн мал аж ахуй байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.19. Батцэнгэл сум Улаанбаатар хотыг холбох засмал замыг дуусгаж, ашиглалтад оруулна.
- 6.1.1.20. Өлзийт, Хайрхан сумыг холбосон авто замыг ашиглалтад оруулах.
- 6.1.1.21. Цэцэрлэг хотын ойролцоо нисэх онгоц буух зурвас бий болгох ажлыг дэмжинэ.
- 6.1.1.22. Эрдэнэбулган сумын 6-р багийн хүүхдийн тамир зусланг өргөтгөнө.
- 6.1.1.23. Жаргалант суманд эмээлийн мод үйлдвэрлэхийг дэмжинэ.
- 6.1.1.24. Эрдэнэбулган суманд хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжинэ.
- 6.1.1.25. Цэцэрлэг суманд рашааныг түшиглэсэн сувилал байгуулахыг дэмжинэ.

ДОЛОО. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ АРХАНГАЙ.

Иргэндээ ээлтэй төрийн бодлогыг хэрэгжүүлж, төрийг иргэдэд үйлчилдэг болгох бүх нөхцөлийг бүрдүүлнэ.

Төрийн албыг чадварлаг, цомхон болгож, цааснаас татгалзсан цахим технологи нэвтрүүлнэ.

7.1. ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ ТӨРИЙН БОДЛОГО

- 7.1.1. Хүний амьдрах орчны аюулгүй байдлын стандартуудыг үе шаттайгаар боловсруулан баталж, төрийн шийдвэр бүрд заавал баримтлах зарчим, шалгууртай болгоно.
- 7.1.2. Хүүхдэд ээлтэй амьдрах орчны стандартуудыг мөрдөн ажиллана.
- 7.1.3. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн үйлчилгээ гэрт ойр байх, хөгжлийн бэрхшээлтэй хүний тусгай хэрэгцээнд нийцсэн стандартыг хэрэгжүүлнэ.
- 7.1.4. Иргэдийн бодитой, үнэн зөв, тэнцвэртэй мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулна.
- 7.1.5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олоннийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэн ажиллана.
- 7.1.6. Хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөний үр дүнд үндэслэсэн нийгэм, эдийн засгийн уян хатан зохицуулалт бүхий төсвийн бодлого хэрэгжүүлнэ.
- 7.1.7. Хүн амын хүнсний аюулгүй байдлын бие даасан байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж, монгол хүнд эрүүл хоол, хүнс хэрэглэх дадлыг төлөвшүүлэн эрүүл, шимт тэжээллэг хоол, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА

- 7.1.8. Төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэл, ажлын байранд тавигдах шалгуур, шаардлагыг тодорхой болгож, нам дагасан томилгооноос салгана.
- 7.1.9. Салбарын мэргэшсэн албан хаагчдыг улс төрөөс ангид, тогтвортой ажиллуулах хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 7.1.10. Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 7.1.11. Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.
- 7.1.12. Төрийн албаны удирдах албан тушаалтны тоог бууруулна.
- 7.1.13. Төрийн байгууллага, удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод ажлын тайлангийн сонсгол хийх үүргийг хуульчлах ажлыг дэмжинэ.
- 7.1.14. Сонгогдсон болон томилогдсон төрийн өндөр албан тушаалтан ёсзүйн зөрчил гаргасан бол олон нийтээс уучлал гуйх, огцруулах, чөлөөлөх хууль зүйн үндэслэлийг хэрэгжүүлж ажиллана.
- 7.1.15. Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендэрийн бодлого хэрэгжүүлнэ.
- 7.1.16. Төрийн албаны мерит зарчмыг хадгална.

7.2. ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 7.2.1. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахимжуулна.
- 7.2.2. Төрийн байгууллагад байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 7.2.3. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.
- 7.2.4. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах цахим засаглалын хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 7.2.5. Төрийн байгууллага, албан тушаалтнаас олгогдох аливаа зөвшөөрлийн журмыг цахимжуулж, бизнест ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 7.2.6. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.
- 7.2.7. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлнэ.
- 7.2.8. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

НАЙМ. ШУДАРГА АРХАНГАЙ.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, хариуцлагыг дээшлүүлэх талаар олон талт арга хэмжээг зохион байгуулах, төрийн албан хаагчдын хууль дээдлэх зарчмыг мөрдүүлэх, төрийн үйлчилгээний олон шат дамжлагыг цөөлөх, албан тушаалтнуудын албан үүргээ гүйцэтгэхдээ баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хийж болох болон үл болох үйлдлүүдийг нарийн зааглан боловсронгуй болгоно.

Сайн засаглалыг бэхжүүлэн хууль ёсыг дээдэлсэн, шударга ёсны итгэл үнэмшлийг бий болгож, ардчилсан нийгмийг бүрэн утгаар нь байгуулсан, хувь хүний

эрх, эрх чөлөө, эдийн засгийн баталгааг хангах бодлого баримтална.

8.1. ХУУЛЬ БА ШУДАРГА ЁС

8.1.1. Иргэний шударга ёс

8.1.1.1. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит ажахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

8.1.1.2. Иргэний ба хуулийн этгээдийн хувийн өмчийн халдашгүй байдлыг хамгаалах хууль, эрх зүйн бодлогыг хэрэгжүүлнэ. Иргэний өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан, шийдвэрлэхгүй хугацаа хэтрүүлсэн төрийн албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэнэ.

8.1.1.3. Гэр бүлийн хүрээнд үүссэн маргаан, зөрчил, хүчирхийллийг зохистой шийдвэрлэх журмыг мөрдөн ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллана.

8.1.2. Нийтийн шударга ёс

8.1.2.1. Авлига, албан тушаалын гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчдийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйг хэрэгжүүлнэ.

8.1.2.2. Хууль дээдэлдэг нийтийн албыг мэргэшүүлэх сургалт зөвлөгөөн зохион байгуулж ажиллана.

8.1.2.3. Төрийн байгууллага, албан тушаалтны "ажил хэргийн нэр хүнд" хэмээх хуулийн томъёоллыг залруулж, төрийн албаны нээлттэй, шилэн байдлыг хэрэгжүүлнэ.

8.1.2.4. Газрын төлөвлөлт, олголтын орчинд реформ хийж, газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.

ЕС. НОГООН АРХАНГАЙ

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэн аймгийн нэр хүндийг дээшлүүлнэ.

Эко системийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүйбус ашиглалтыг зогсоох, цөлжилтийг сааруулах, "ногоон байгаль" бодлогыг хэрэгжүүлэн байгалийн жам ёсоор сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжин хүний амьдралын чанарыг сайжруулна.

9.1. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

9.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэн, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах байгуулна.

9.2. ГАДААД ХАРИЛЦАА

9.2.1. Гадаад улс орны ижил төстэй засаг захиргааны нэгж, хот сууринуудтай эдийн засаг, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл урлаг, спорт, аялал жуулчлалын чиглэлээрх хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

9.2.2. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчинг бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн зүгээс бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

9.2.3. Өндөр технологи, инновацыг нэвтрүүлэх зорилгоор гадаадаас экспертүүдийг урьж ажиллуулах санал санаачилгыг бүрэн дэмжиж ажиллана.

9.2.4. Төрийн албан хаагчдыг гадаад арга хэмжээнд оролцуулах, туршлага судлуулах, мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

9.3. БАТЛАН ХАМГААЛАХ

9.3.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүүхэд залууст эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ОНЦГОЙ БАЙДЛЫН САЛБАР

- 9.3.2. Эрдэнэмандал суманд Онцгой байдлын газрын харьяа ангийг байгуулна.
- 9.3.3. Онцгой байдлын газрын албан хаагчдыг мэргэшүүлсэн сургалтад хамруулна.
- 9.3.4. Онцгой байдлын газрын түргэн тусламж, галын дуудлага, аваар осол, халдварт өвчин, гамшгийн үед ажиллах техник хэрэгсэл, хувцас, тоног төхөөрөмжөөр хангах ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 9.3.5. Онцгой байдлын алба хаагчдыг олон улсын аврах ажиллагааны солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

9.4. АМЬД БАЙГАЛЬ

Байгаль орчин, эко системийн тэнцвэрт байдал

- 9.4.1. Ус, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 9.4.2. Тусгай хамгаалалттай газар нутгийг судалгааны үндсэн дээр нэмэгдүүлж, онцлог эко системийн үйлчилгээ, үнэ цэнийг өсгөнө.
- 9.4.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулах, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 9.4.4. Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, ус ашиглалтын үр ашиг, хэмнэлтийг сайжруулна. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 9.4.5. Аймгийн төв болон суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар чөлөөлөх, усны нөөц бохирдох, хомсдохоос сэргийлэх чиглэлээр гарсан хууль, эрх зүй бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 9.4.6. Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангана.
- 9.4.7. Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн эко төлбөрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.
- 9.4.8. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг аймгийн хэмжээнд үе шаттай зохион байгуулж, нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 9.4.9. Олон талт байгаль хамгааллын менежмент, техник, технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг сайжруулна.
- 9.4.10. Эко систем, биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж байгаа аж ахуй эрхлэлтэд олгодог татаасыг бууруулж, эко системийн үйлчилгээг тэтгэсэн, хамгааллын үйл ажиллагааг дэмжинэ.
- 9.4.11. Байгаль хамгааллын шинжлэх ухаан, дэвшилтэт технологид түшиглэсэн мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлнэ.
- 9.4.12. Тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 9.4.13. Эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээх ашиглагчийн хариуцлагыг өндөржүүлэн аж ахуйн зориулалтаар дахин ашиглах боломжтой болгож, эргэлтэд оруулна.
- 9.4.14. Амьтан, ургамлын ховордсон зүйлийг тодорхойлон, хамгааллын арга замыг хэрэгжүүлнэ.
- 9.4.15. Ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, тарималжуулах, ойн агропарк байгуулах замаар ашиглалтын нөөцийг бүсчлэн бий болгож, байгалийн нөөцийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 9.4.16. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын болон аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.

Ойжуулалтын шинэчлэл

- 9.4.17. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ арга аргачлал, технологи нэвтрүүлнэ.
- 9.4.18. Ойн тэлэн ургалтыг дэмжих, ойжуулах, нөхөн сэргээх зэрэг ой хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх замаар ойн хомсдолоос сэргийлнэ.
- 9.4.19. Иргэд аж ахуй нэгжээс ойг нөхөн сэргээх, ойжуулах, байгалийн сэргэн ургалтын талаар хийж байгаа төсөл арга хэмжээг болон, ойн хамгаалалтын зурвас байгуулахыг дэмжинэ.
- 9.4.20. Ойжуулах, хүлэрт намгийг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, ургамлын нөмрөгийг хамгаалах, ургамалжуулах замаар хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлнэ.
- 9.4.21. Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой, рашаан, булгийг хамгаалах чиглэлээр өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 9.4.22. Ой болон бэлчээрт хөнөөл учруулж буй шавж, мэрэгч амьтадтай байгальд ээлтэй аргаар тэмцэж, энэ чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Цөлжилттэй тэмцэх

- 9.4.23. Аймаг, орон нутагт газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Иргэдийн мод тарих санаачилгыг дэмжиж, бүртгэлийг цахимжуулах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ..
- 9.4.24. Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- 9.4.25. Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ